



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А1618

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, 4.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.6 дахь зорилт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 38 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулагдаж байгаа “Алтай түншлэл-2022” үзэсгэлэн худалдааг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх арга хэмжээг зохион байгуулагдахад шаардагдах 1,588,000 (нэг сая таван зуун наян найман мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201002021

Аймгийн Засаг даргын оны
..... дугаар сарын-ны өдрийн дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
10	Гадна анонс	м2	30	14,000	420,000
11	Дотор анонс	м2	24	12,000	192,000
12	Бусад зардал (заалны чимэглэл, скоч, уяа)	ширхэг	70	12,000	840,000
13	Тайз засахад (заалны чимэглэл, анонс байршуулахад)	-	-	-	136,000
	Дүн				1,588,000

__оОо__